



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠤ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠡ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 4/263

Алтай хот

Ор дэлгэн ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 33 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Коронавируст халдвар (Ковид-19)-тай иргэнийг хэвтүүлэн эмчлэх орыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, "Алтайн хүдэр" ХХК, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, "Машид-Эрдэнэ" ХХК-ийн Цогц төв эмнэлэгт тус тус дэлгэн ажиллуулсугай.

2.Эмнэлзүйн заавраар эрэмбэлэн ангилалтыг хийж, дэлгэсэн орны тоо, зохицуулалтын дагуу тусламж үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй үзүүлэхийг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Ц.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Коронавируст халдвар (Ковид-19)-тай иргэдийг хэвтүүлэн эмчлэхтэй холбоотой зардлыг зохих тушаал, журмын дагуу хянаж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын хэлтэс (Б.Энхцэцэг)-т даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР